



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/47

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоол, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.1.80 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барих барилга байгууламжийн “ажлын гүйцэтгэл”-ийн төсвөөс санхүүжүүлэх зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 1 дүгээр, аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сан”-аас санхүүжүүлэх инженер геологийн дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээний төлбөрийн төсөвт өртгийн дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг хавсралтад заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг, төсөл, техникийн нөхцөл, техникийн тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийг бэлтгэн төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

2023.02.03

6710010308

Аймгийн Засаг даргын 2023 оны 02
дугаар сарын 03-ны өдрийн
А/ч дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР БАРИХ БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖИЙН “АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-ИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮДЭХ
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН
ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Эрүүл мэндийн төвийн барилгын /Хөвсгөл, Мөрөн сум, 7, 8, 13 дугаар баг/ ажлын зураг төсөл боловсруулах	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	20,000,000	

Аймгийн Засаг даргын 2023 оны 02
дугаар сарын 03-ны өдрийн
А/4 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ “ЗУРАГ ТӨСВИЙН САН”-ААС
ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Эрүүл мэндийн төвийн барилгын /Хөвсгөл, Мөрөн сум, 7, 8, 13 дугаар баг/ инженер геологийн дүгнэлт	2,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
2	Спорт заал /Мөрөн сум/-ны инженер геологийн дүгнэлт	2,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	4,000,000	